



Монгол Улс: ОУВС-гийн Монгол Улсыг хариуцсан ажлын хэсгийн 2024 онд хийсэн айлчлалын дүгнэлт

ОУВС-гийн ажлын хэсгийн ихэнх тохиолдолд гишүүн оронд хийсэн албан ёсны айлчлалыг дүгнэж гаргасан урьдчилсан үр дүнг энэхүү дүгнэлтэд танилцуулдаг. ОУВС-гийн Дүрмийн 4-р заалтын ээлжит (ихэнхдээ жил бүр) зөвлөлдөх хэлэлцүүлэг хийх, ОУВС-гийн эх үүсвэрийг ашиглах (ОУВС-гаас зээл авах) талаар гаргасан хүсэлтийг судлах, ажлын хэсгийн хяналт дор хэрэгжиж байгаа хөтөлбөрийн яриа хэлэлцээ явуулах, эсхүл эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийг ажлын хэсэг шинжлэх зорилгоор ийм айлчлал хийдэг. Эрх баригчид энэхүү дүгнэлтийг хэвлэн нийтлэх зөвшөөрлийг өгсөн болно. Энэхүү дүгнэлтэд тусгасан байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн байр суурь бөгөөд ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг гарцаагүй илэрхийлэхгүй. Энэхүү айлчлалын урьдчилсан үр дүнд үндэслэн ажлын хэсэг тайлан гаргах бөгөөд тайланг ОУВС-гийн удирдлагад танилцуулж зөвшөөрөл авсны дараа ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.

Улаанбаатар, Монгол Улс – 2024 оны 10-р сарын 1

- *Шинээр эмхлэн байгуулагдсан эвслийн засгийн газрын тэргүүлэх чиглэл нь одоо явагдаж байгаа түүхий эдийн үнийн өсөлтийг дагасан тэлэлтийг зөв зохистой удирдах замаар томоохон зорилт бүхий шинэчлэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө үр дүнтэй хэрэгжүүлэх явдал юм.*
- *Гадаад секторын болон төсвийн нөөцийг нэмэгдүүлэх нь томоохон зорилт бүхий хөрөнгө оруулалт, бусад шинэчлэлийг эдийн засгийн шингээх чадвартай уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэх бодлогын орон зайг бий болгож, улмаар гадаад болон дотоод тэнцвэрт байдлыг хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ. Одоогийн нөхцөл байдалд эдгээр зорилтод хүрэхийн тулд төсвийн бодлогыг хумьж, төсвийн тусгай шаардлагыг дагаж мөрдөн, мөнгөний болон макро зохистой хатуу бодлого баримтлан, санхүүгийн салбарын хяналт шалгалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.*
- *Бизнесийн орчин, засаглалыг сайжруулахын тулд хууль эрх зүй, зохицуулалт, институцийн орчинд хамаарах зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэхэд ахиц дэвшил гаргах нь хатуу дэд бүтцийг бүтээн байгуулахтай ижил ач холбогдолтой юм. Тухайлбал, чухал дүрэм журмыг шинэчлэн сайжруулах, зохицуулалтын механизмын уялдаа холбоог хангах, төв банкны үйл ажиллагааны бие даасан хараат бус байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Өрийн хязгаарыг нэрлэсэн дүнгээр тогтоож, хатуу мөрдөх шаардлага тавьсан нь маш чухал бөгөөд сайшаалтай шийдвэр болсон. Мөн удаан хугацаанд хүлээгдэж, эрчим хүчний дотоодын нийлүүлэлтийн найдвартай байдлыг хангахад шаардлагатай байгаа эрчим хүчний тарифын шинэчлэл чухал байна. Дэд бүтцийн төслүүдийг ач холбогдлоор нь зөв эрэмбэлж, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд зохих тооцоо судалгааг хийж, төсвийн*

дунд хугацааны төлөвлөлтийг бэхжүүлж, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг зохистой болгох нь зүйтэй.

Эдийн засаг: Түүхий эдийн үнийн өсөлтийг дагасан тэлэлт

Зудын нөхцөл байдлаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбар их уналттай байсан хэдий ч **уул уурхайн салбар эрчимтэй тэлж, нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрч, засгийн газар болон өрхийн хэрэглээ нэмэгдсэний үр дүнд эдийн засаг их өндөр өсөлттэй гарлаа.** 2023-2024 онуудын төсөвт цалин хөлс, тэтгэврийг их хэмжээгээр нэмсэн, Эрдэнэс тавантолгой компаниас хувьцаа эзэмшигч иргэдэд томоохон ногдол ашиг хуваарилсан, засгийн газраас эдийн засгийн дэмжих хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн, цалингийн доод хэмжээг өсгөсөн зэрэг нь өрхийн орлого, цалингийн зээлийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, хэрэглээ, импортыг дэмжсэн байна. Засгийн газрын зарлага их хэмжээгээр нэмэгдсэн боловч төсвийн орлого бүрдүүлэлт өндөр гүйцэтгэлтэй байж, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт оны төгсгөл рүү түлхүү бүртгэгддэг зэрэг нь төсөв ашигтай гарахад нөлөөлжээ. Засгийн газрын өрийн хэмжээ 2023 оны эцэст ДНБ-ий 47 хувь болж буурсан нь ОУВС-гийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын хувьд баримталбал зохих өрийн үзүүлэлттэй нийцтэй байна.

Инфляц буурч, Монголбанкны зорилтот интервал болох 6 ± 2 хувь дотор байна.

Импортын барааны үнэ буурч, төгрөгийн ханш бага зэрэг чангарсны үр дүнд инфляц багассан бөгөөд улмаар бодлогын хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Гэхдээ суурь инфляц төдийлөн сайн буураагүйн дээр 8-р сарын байдлаар инфляцын зорилтот интервалын дээд хязгаарт хүрсэн байдалтай байна. Цаашилбал, банкны болон банк бус санхүүгийн байгууллагын зээл, тэр дундаа хэрэглээний зээлийн өсөлт урт хугацааны хандлагаас давж нэмэгдлээ. Монголбанк үүний эсрэг хариу арга хэмжээ болгож заавал байлгах нөөцийн шаардлага, хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны үзүүлэлтийг чангатгав. Өрх, нэн ялангуяа тодорхой ангиллын зээлдэгчдийн өр хурдацтай нэмэгдэж байна.

Хэдийгээр импорт өсөж, нүүрсний экспортын үнэ буурсны улмаас **урсгал дансны алдагдал мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн боловч гадаад секторын эмзэг байдал буурсан байна.** Гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн бусад орох урсгал гадаад валютын нийт нөөцийг өсгөж, 2023 оны эцэст байсан түвшинд хадгалагдах нөхцөлийг бүрдүүллээ (8-р сарын эцсийн байдлаар 4.7 тэрбум ам. доллар, 3.3 сарын импорт буюу АРА хэмжүүрийн 96 хувь). Засгийн газар гадаад өрийн дахин санхүүжилтийг оновчтой зохион байгуулж, Монголбанк Хятадын ардын банкнаас авсан своп хэлцлийн өрийн үлдэгдлийн тэн хагасыг төлж барагдуулсан нь гадаад өрийн эрсдэлийг бууруулж, тус улсын зээлжих зэрэглэлийг В+ болгож сайжрууллаа.

Цаашдын төлөв: Түүхий эдийн үнийн өсөлт үргэлжилж, эдийн засаг эрчимтэй өсөх боловч тэнцвэргүй байдал нэмэгдэх хандлагатай

2024-2025 онуудад өндөр агууламжтай зэсийн үйлдвэрлэл, БНХАУ руу гарах нүүрсний экспорт нэмэгдэж уул уурхайн салбарын эрчимтэй өсөлт үргэлжлэхийн зэрэгцээ мөчлөг дагаж ихээхэн тэлсэн 2024 оны төсвийн тодотгол, 2025 оны төсвийн төслийн үр нөлөөгөөр **эдийн засгийн өсөлт өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй байна.**

Засгийн газрын төлөвлөгөөнд орсон мега төслүүдийн¹ хэрэгжилтийг гадаад санхүүжилтийн эх үүсвэрийн олдоцтой уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэж тооцвол төсвийн алдагдал 2029 он хүртэл тогтмол нэмэгдэж, санхүүжилтийн нийт хэрэгцээ, засгийн газрын өр, төсвийн эрсдэлийг өсгөхөөр байна. Гарцын зөрүү 2028 он дуустал эерэг дүнтэй байхаар байна.

Төсвийн тэлэх бодлого нь Монгол Улсын гадаад болон дотоод тэнцвэргүй байдлыг улам нэмэгдүүлэхээр байна. Инфляц 2024 оны сүүлийн хагаст үргэлжлэн өсөж 2026 он хүртэл зорилтот түвшингээс дээгүүр байхаар байна. Үүний гол шалтгаан нь хийгдэхээр төлөвлөгдсөн их хэмжээний төсвийн дэмжлэг, 2024 оны төсвийн тодотгол, 2025 оны төсвийн төслийн хүрээнд бий болсон зардлын тэлэлт, эрчим хүчний тарифын өөрчлөлт, зээлийн өндөр өсөлтийн үр нөлөө цаг хугацааны хоцрогдолтой илрэхтэй холбоотой юм. Хөрөнгө оруулалтын төслүүдийн импортын хэрэгцээ өндөр байдаг учир урсгал дансны алдагдал багасахгүй бөгөөд энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирж, гадаад зээллэг шинээр хийсэн ч гадаад валютын нийт нөөцийн хүрэлцээг бууруулахаар байна.

Эдийн засгийн үзүүлэлтүүдийг төсөөллийг мега төслүүдийг хэрэгжүүлэх үйл явц, санхүүжилт, хувийн хэвшлийн оролцоо зэрэг асуудлууд хараахан бүрэн шийдэгдээгүй зэрэг **нэлээдгүй тодорхой бус нөхцөлд хийгдэж байна.** Хөрөнгө оруулалтын зардлын импортын хэрэгцээ өндөр байдгаас шалтгаалан мега төслүүдийг хэрэгжүүлэхдээ дотоод эх үүсвэрийг түлхүү ашиглахын хэрээр гадаад валютын нийт нөөц, ханш, инфляцад үзүүлэх нөлөөлөл нэмэгдэх болно. Гэхдээ 2024 оны ДНБ-ий 67 хувьтай тэнцэх хэмжээний гадаад санхүүжилтийг 4-5 жилийн хугацаанд босгоно гэдэг амаргүй байх болов уу. Төсөл хэрэгжүүлэхэд эдийн засгийн багтаамж, санхүүжилтийн хязгаарлалттай нүүр туулах магадлал өндөр учраас хөрөнгө оруулалтын төслүүдийг ээлж дараатайгаар хэрэгжүүлэх нь илүү бодитой байх бөгөөд ингэснээр макро эдийн засгийн одоогийн төлөвийг сайжруулах боломжтой юм.

Түүхий эдийн үнийн хэлбэлзэл, БНХАУ-ын нүүрсний эрэлттэй холбоотой тодорхой бус байдал, ОХУ-аас авах түлшний импортын саатал, Монгол Улсын транзит тээврийн чухал боомт болох БНХАУ-ын Тяньжин боомт дээр хүлээгдэл зэргээс шалтгаалан **эдийн засгийн төлөв доройтох эрсдэлүүд мөн байна.** Мөн засгийн газрын зохицуулалт, дүрэм журмын хүрээнд үүсч болзошгүй саад тотгорын улмаас зэсийн үйлдвэрлэл, экспорт тасалдах эрсдэл бий. Байгалийн гамшиг, геополитикийн нөхцөл байдал тодорхой бус байдлыг даамжруулна. Түүхий эдийн үнэ эсвэл БНХАУ руу гаргах экспорт ялангуяа ойрын хугацаанд тооцоолж байгаагаас илүү өндөр гарах нь эдийн засгийн төлөвийг сайжруулах боломжтой. Мөн түүнчлэн, дунд хугацаанд уул уурхайн шинэ төслүүд хэрэгжиж, экспортыг нэмэгдүүлэх боломжтой.

Бодлого: Эдийн засгийн өсөлтийн эрчийг хадгалж үлдэх үүднээс түүхий эдийн үнийн өсөлтийг ухаалгаар удирдах

А. Төсвийн зардлыг хумьж, тусгай шаардлагуудыг хангах: эн тэргүүний бодлогын зорилт

Гадаад болон дотоод тэнцвэрийг хангаж, одоо явагдаж байгаа тэлэлтийн хугацаанд нөөц бүрдүүлж, инфляцийн эрсдэлтэй тэмцэж байгаа мөнгөний бодлого дээр ирж буй

¹ Засгийн газар 2024 оны ДНБ-ий 67 хувьтай тэнцэх хэмжээний өртөг бүхий 14 мега төслийг 2025-2029 онуудад хэрэгжүүлэхээ зарласан бөгөөд үүний ДНБ-ий 15.4 хувьтай тэнцэх санхүүжилт нь төсвийн хөрөнгө оруулалтаас гарах тооцоотой байна.

дарамтыг бууруулахын тулд **төсвийн бодлогыг хатууруулах шаардлагатай байна.** Хөрөнгө оруулалтыг дэмжихийн хажуугаар төсвийн алдагдлыг бууруулахын тулд төсвийн урсгал зардлыг бууруулж, уул уурхайн бус орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг нэмж авах хэрэгтэй. Тухайлбал, цалингийн зардлыг нэмэхгүй байх, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, хувь хүний орлогын албан татварын шатлалыг нэмэх, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг бууруулах, татвар, гаалийн удирдлагын хүрээнд шинэчлэлийг хэрэгжүүлэх зэрэг болно ([ОУВС-гийн 2023 оны тайлан](#)).

Төсвийн зарлагыг дэд бүтцийн хөрөнгө оруулалт рүү чиглүүлэх нь бүтээмжийг нэмэгдүүлэх хэдий ч эдийн засгийн шингээх чадварт нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсын гадаад секторын эмзэг байдал болон импортын хамаарал өндөр, дотоодоос санхүүжилт татах хүчин чадал хязгаарлагдмал, олон улсын санхүүгийн зах дээр эх үүсвэр дутагдалтай, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоо бүрэн бэхжээгүй зэргийг бодолцож засгийн газар анхаарал болгоомжтой ажиллах нь зүйтэй. Эдийн засгийн тэлэлт явагдаж байгаа үед нөөц бүрдүүлэх нь нэн чухал шаардлагатай хөрөнгө оруулалтыг шат дараатайгаар, илүү үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл болох юм. Төсвийн болон гадаад эрсдэлийг хянах, хөрөнгийн зардлыг чиглүүлэх үүднээс илүү үр дүнтэй дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, тэр дундаа хөрөнгө оруулалтын зардлыг тусгаж өгөх нь чухал байна. Тооцоо судалгааг зохих ёсоор хийхийн зэрэгцээ авилга, үр өгөөжгүй төслүүдээс сэргийлэх үүднээс төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль эрх зүйн орчинг чанд дагаж мөрдөн хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагаар нь сайн эрэмбэлэх хэрэгтэй.

Засгийн газрын өрийн таазыг нэрлэсэн дүнгээр ДНБ-ий 60 хувиар тогтоох болсон нь Монгол Улсын төсвийн тусгай шаардлагыг бэхжүүлэх чиглэлд хийсэн томоохон алхам болсон. Ингэснээр ил тод байдал, хариуцлага нэмэгдэж, хууль мөрдөх хатуу шаардлага бий болсон. Төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлын дээд хязгаарыг авч үлдсэнээр төсвийн тэнцэл хэт ихээр муудахаас сэргийлэхэд дэмжлэг болох учиртай. Юутай ч өрийн одоогийн түвшин өрийн таазны хязгаараас нэлээд доогуур байгаа нь дээрх хоёр тусгай шаардлагын аль нь ч төсвийн зардлыг одоогоор хангалттай хазаарлаж чадахгүй. Шинээр тодорхойлсон зарлагын тусгай дүрэм мөчлөг дагасан шинжтэй байгаа тул эдийн засаг тэлж байгаа үед төсвийн зардлыг нэмэгдүүлэхэд нөхцөл болохын хажуугаар эдийн засаг агшиж байгаа үед төсвийн зардлыг таных шаардлагыг үүсгэж, эдийн засгийн мөчлөгийн нөлөөллийг даамжруулах эрсдэлтэй байна. Төсвийн нийт зардлын өсөлтийг хязгаарласнаар зардлыг буруу ангилах эрсдэлээс хамгаалах боломжтой болно. (ОУВС-гийн мэргэжилтнүүд төсвийн нийт зардлыг хязгаарлахад чиглэсэн зохих тусгай шаардлага боловсруулахад засгийн газарт туслалцаа үзүүлэхэд бэлэн байна. Ингэснээр засгийн газар шинэчлэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх боломж бүрдэх юм.) Төсвийн тусгай шаардлагыг ойрхон давтамжтай өөрчлөх нь бодлогын зорилт болох үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бууруулж магадгүй учраас зайлсхийх нь зүйтэй.

В. Дотоодын санхүүгийн нөхцөлийг чангатгах

Мөнгөний болоод макро зохистой бодлогоор дотоодын санхүүгийн нөхцөлийг хатуу хэвээр байлгахад үргэлжлүүлэн анхаарах нь зүйтэй. Төсвийн алдагдлыг бууруулаагүй нөхцөлд инфляц өсөх магадлалтай байгаа учраас инфляц зорилтот интервалд тогтворжих нь илүү тодорхой болох хүртэл бодлогын бодит хүүг өндөр түвшинд хадгалж байхыг Монголбанканд зөвлөж байна. Монголбанкны инфляцын

төсөөллийг харгалзан үзвэл мөнгөний бодлогын байр суурийг 2024 оны 9-р сард хэвээр хадгалах нь илүү оновчтой байсан юм. Нөгөө талдаа банкны зээлийн өсөлтийн эрчийг сааруулах зорилгоор өр, орлогын харьцаа, заавал байлгах нөөцийн шаардлагыг чангатгасан нь цагаа олсон зохистой шийдвэр болсон. Гэхдээ энэ чиглэлээр нэмж арга хэмжээ авах шаардлагатай (доор дэлгэрүүлэв). Засгийн газраас үнэт цаасаа дотоодын зах дээр гаргаж эхлэн төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох төлөвлөгөөтэй байгаа нь мөнгөний бодлогын шилжих механизмыг сайжруулахад дэмжлэг болохоор байна.

С. Эрсдэл даах чадварыг бэхжүүлж, шинэчлэл хэрэгжүүлэх бодлогын орон зайг нэмэгдүүлэх зорилгоор гадаад валютын нөөцийг бүрдүүлэх

Монгол Улсын гадаад шокийн эрсдэлийг даах чадварыг бэхжүүлж, засгийн газраас дэвшүүлсэн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх орон зайг бий болгоход гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх нь шийдвэрлэх ач холбогдолтой юм. Энэ хүрээнд Монголбанк ханшийг илүү уян хатан байлгаж, гадаад шокийг шингэхэд ашиглах нь зүйтэй. Засгийн газар экспортын гэрээнд хяналт тавих тогтолцоогоо түлхүү ашиглан ТӨК-удын борлуулалтын орлогоо гадаадаас оруулж ирдэг байх шаардлагыг сайн хэрэгжүүлж, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хатуу мөрдүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаадын хувийн санхүүжилтийг шинээр татах шинэчлэлийг авч хэрэгжүүлэх шаардлагатай (доор дэлгэрүүлэв). Гадаад секторын тогтвортой байдлыг хангах зорилгоор хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийг харилцан уялдуулах бодлогыг тодорхойлох Монголбанк, Сангийн яам, Эдийн засаг хөгжлийн яамны төлөөллийг багтаасан ажлын хэсгийг шинээр байгуулсан нь маш зүйтэй санаачлага бөгөөд засгийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд хэрэгтэй мэдээлэл гаргаж өгөх учиртай.

Д. Санхүүгийн салбарыг тогтвортой байдлыг хангах

Санхүүгийн салбарын хяналт шалгалтын хүрээнд шинээр үүсч байгаа эрсдэлийг, нэн ялангуяа санхүүгийн салбарт зээлийн өсөлт эрчимтэй явагдаж байгаа энэ үед зээлийн эрсдэлийг **хянахдаа сонор сэрэмжээ алдахгүй байх нь зүйтэй.** Эдийн засгийн эрчимтэй, зээлийн хурдацтай өсөлтийн үед сайжирч харагдаж буй санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд суурь эмзэг байдлыг халхавчилж байж болзошгүй. ББСБ дээр мөрдөж буй өр, орлогын харьцааг бууруулахдаа банкны салбарт мөрдөж буй доод хэмжээтэй цаг алдалгүй уялдуулах нь илүү үр дүнтэй байх болно. Ингэснээр зохицуулалтын зөрүүтэй байдлыг ашиглахаас сэргийлж, хэрэглээний зээлийн өсөлтийг сааруулах ач холбогдолтой юм. Зохицуулагч байгууллагууд өр, орлогын харьцааг үр дүнтэй мөрдүүлэх тогтолцоог бэхжүүлж, FICO зээлийн оноог ойрын хугацаанд хэрэглэж эхэлснээр санхүүгийн боловсролын түвшинг нэмэгдүүлж, хэт их зээлийн өртэй зээлдэгчид дахин нэмж зээл авахаас сэргийлэх үр дүнтэй механизм бүрдүүлэх юм. ББСБ-ын дүрэм журмыг чанд мөрдүүлж, тогтолцоог бэхжүүлэх өөрчлөлт агуулсан шинэчилсэн зохицуулалтыг ойрын хугацаанд батлах нь эрсдэлийг бууруулахад дэмжлэг болно. Монголбанк, СЗХ-ны хянан шалгагч нар банк болон ББСБ-ын хооронд байгаа харилцан хамаарлыг олж тогтоон, багасгах арга хэмжээ авснаар санхүүгийн салбарын эмзэг байдал, системийн эрсдэлийг урьдчилж бууруулах боломжтой. Энэ хүрээнд шаардлагатай бол зорилтот хяналт шалгалт явуулж, нөөцийн сан байгуулах тусгай шаардлага тавьж болно. Монголбанкны Ерөнхийлөгч Төв банкны тухай хуулиар олгосон эрх мэдлээ хэрэгжүүлж, санхүүгийн салбарын хяналт шалгалтыг хариуцсан албан тушаалтныг нэн даруй томилох замаар санхүүгийн салбарын эрсдэлийн удирдлага, шинэчлэлийн хэрэгжилтэд дэмжлэг болох учиртай.

Санхүүгийн салбарын төлбөрийн чадвартай зээлдэгчдэд зээл олгох чадавхийг илүү өргөн хүрээний шинэчлэлээр дамжуулан бэхжүүлэх шаардлагатай байна.

Төлбөрийн чадваргүйдэл, зээлдүүлэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, санхүүгийн байгууллагууд чанар муутай активын асуудлаа шуурхай шийдвэрлэхэд нь дэмжлэг болох хэрэгтэй. Банкны нэг хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийн дээд хязгаарыг 2026 оны эцэст багтаан хангаж, банкны салбарын шинэчлэлийг зорилтод нь хүргэх үүднээс Монголбанк хувьцаа эзэмшигчдийг төрөлжүүлэх талаар гаргасан хугацаатай төлөвлөгөөний хэрэгжилтийг үргэлжлүүлэн хянах нь зүйтэй. Банкны хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийн дээд хязгаарыг өсгөснөөр банкны үр дүнтэй удирдаж, үйл ажиллагааг нь явуулахад нэн ач холбогдолтой бөгөөд зарим олон улсын санхүүгийн байгууллагууд хэд хэдэн банканд хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Е. Зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэх нь тогтвортой өсөлтөд мөн ижил ач холбогдолтой.

Монголын бизнесийн орчин, засаглалыг сайжруулах нь эрчимтэй бөгөөд тогтвортой өсөлтөд чухал үүрэгтэй. Зөөлөн дэд бүтцийн шинэчлэлийн гол тэргүүлэх чиглэлүүдийг дурдвал Хөрөнгө оруулалтын тухай хуулийг боловсронгуй болгож, хүнд суртлыг багасгах, Эрдэс баялгийн тухай хуулийг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх, ТӨК-ийн тухай, Төлбөрийн чадваргүйдлийн тухай, Шүгэл үлээгчийн тухай хуулиудын төслийг батлах явдал юм. ТӨК-ийн засаглалын шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлж, хүчирхэг шүүх засаглалтай байх нь шаардлага мөн байгаа бөгөөд Монголбанкны үйл ажиллагааны бие даасан хараат бус байдлыг хангах нь ижил ач холбогдолтой. Эрчим хүчний тарифыг шинэчлэхээр төлөвлөсөн нь удаан хугацаанд хүлээгдэж байгаа зайлшгүй шаардлагатай ажил юм. Ингэснээр өрх, аж ахуйн нэгжид очих эрчим хүчний нийлүүлэлт найдвартай болж, урт хугацааны өсөлтийг нэмэгдүүлэхээр байна. Тарифын өөрчлөлтийг олон нийтэд сайтар тайлбарлаж, зохистой хугацаанд үе шаттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ орлого багатай өрхүүдийн шилжилтийн үеийн зардлыг хуваалцах зорилгоор түр хугацаанд зорилтот бүлэгт чиглэсэн дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Зохицуулалтын орчин татварын хууль тогтоомж, татварын маргааныг үр дүнтэй шийдвэрлэх тогтолцоотой нийцтэй байх нь гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг болж, гадаадын хөрөнгө оруулалтыг шинээр татахад тустай. Үндэсний баялгийн санг шинээр байгуулсан нь зүйтэй алхам болж байгаа хэдий ч дэд сангуудын засаглалын хүчирхэг тогтолцоог яаралтай бүрдүүлэх хэрэгтэй байна.

ОУВС-гийн ажлын хэсэг 2024 оны 9-р сарын 25-наас 10-р сарын 1-ний өдрүүдэд Улаанбаатар хотод ирж ажиллалаа. Илэн далангүй, үр бүтээлтэй хэлэлцүүлэг өрнүүлж, элэгсэгээр хүлээж авсан Монгол Улсын эрх баригчдад талархал илэрхийлье.

Монгол Улс: Эдийн засаг, санхүүгийн зарим үзүүлэлтүүд , 2021-2029 онууд

	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029
	Гүйцэтгэл			Төсөөлөл					
	(ДНБ-д харьцуулсан хувиар, тусгайлан зааснаас бусад тохиолдолд)								
Үндэсний тооцоо									
ДНБ, оны үнээр (сая ам.долл)	15,286	17,146	20,315	23,669	27,242	29,120	31,569	34,024	36,400
ДНБ-ий бодит өсөлт (өөрчлөлт, хувиар)	1.6	5.0	7.4	5.5	7.0	6.0	5.5	5.5	5.0
ДНБ (зэрэгцүүлэх үнээр) дэх оролцоо (нэгж хувиар)									
Дотоод эрэлт	17.6	11.4	5.6	20.2	8.3	7.6	10.0	8.8	7.2
Бараа үйлчилгээний экспорт	-7.5	13.9	17.9	1.6	7.3	6.5	0.9	2.8	4.5
Бараа үйлчилгээний импорт	-8.5	-20.3	-16.2	-16.4	-8.6	-8.2	-5.4	-6.1	-6.6
Хэрэглээ	67.9	65.8	57.5	61.5	60.4	61.5	63.0	63.6	63.2
Хувийн сектор	53.0	51.9	44.5	46.7	45.8	47.1	48.7	49.4	48.9
Төрийн байгууллага	14.9	13.9	13.0	14.7	14.6	14.4	14.3	14.2	14.2
Хөрөнгийн нийт хуримтлал	36.7	42.3	33.9	35.9	35.4	35.3	35.5	35.8	36.0
Үндсэн хөрөнгийн хуримтлал	26.8	29.8	25.3	26.6	28.4	29.3	29.3	29.6	29.8
Төрийн байгууллага	6.8	7.1	7.4	9.9	10.3	10.0	10.0	10.0	10.0
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	13.5	14.2	10.7	8.6	9.3	10.3	9.9	9.4	9.1
Дотоодын хувийн сектор (ТӨК-уудыг оруулсан)	6.5	8.6	7.3	8.1	8.8	9.0	9.4	10.2	10.6
Үндэсний нийт хуримтлал	22.9	28.9	34.5	29.0	27.7	27.0	26.3	26.2	26.7
Үнэ									
Хэрэглээний үнэ (дундаж өөрчлөлт хувиар) 1/	7.4	15.2	10.3	6.5	9.0	8.3	7.6	7.2	6.7
Хэрэглээний үнэ (хугацааны эцэс дэх өөрчлөлт хувиар) 1/	13.9	13.2	7.9	7.5	9.5	7.6	7.5	6.8	6.5
Зэсийн үнэ (нэгж тонн ам. долл)	9317	8829	8491	9298	9450	9550	9584	9584	9584
Нүүрсний үнэ (нэгж тонн ам.долл)	150	123	131	115	105	105	105	105	105
ДНБ-ий дефлятор (өөрчлөлт хувиар)	14.4	17.7	21.8	10.0	8.9	6.7	8.1	7.1	6.6
Засгийн газрын данс									
Суурь тэнцэл (ОУВС-гийн тодорхойлолтоор)	9.7	2.2	4.3	1.8	0.3	0.3	-0.3	-0.4	-0.1
Нийт орлого, тусламжийн дүн	32.8	34.4	34.6	37.6	36.5	35.6	34.7	34.4	34.8
Суурь зарлага ба цэвэр зээл	23.2	32.2	30.3	35.9	36.2	35.4	35.0	34.9	34.9
Хүүгийн зардал	1.9	1.5	1.6	1.4	1.3	1.3	1.5	1.5	1.6
Нийт тэнцэл (ОУВС-гийн тодорхойлолтоор)	7.8	0.7	2.7	0.4	-1.0	-1.1	-1.8	-2.0	-1.7
Уул уурхайн бус суурь тэнцэл (ДНБ-д эзлэх хувиар)	2.0	-6.3	-5.7	-10.3	-11.1	-10.6	-10.4	-10.2	-9.9
Санхүүжилтийн нийт хэрэгцээ	2.5	3.8	15.3	5.2	4.1	10.1	7.1	7.8	7.0
Засгийн газрын өр 2/	67.7	64.5	46.8	42.4	40.0	40.7	42.4	44.8	47.3
Дотоод	3.2	4.4	3.4	3.6	3.0	3.3	3.5	3.8	4.0
Гадаад	64.6	60.1	43.4	38.7	37.0	37.5	38.9	41.0	43.3
Мөнгө зээл									
Нийт мөнгөний өсөлт (өөрчлөлт хувиар)	13.8	6.5	26.8	20.0	15.9	11.9	12.3	11.8	14.2
Нөөц мөнгөний өсөлт (өөрчлөлт хувиар)	6.5	39.9	7.4	20.1	13.7	11.9	12.3	11.8	12.1
Зээлийн өсөлт (өөрчлөлт хувиар)	18.1	8.6	22.0	24.0	16.0	14.2	13.5	13.5	13.5
Төлбөрийн тэнцэл									
Урсгал дансны тэнцэл	-13.8	-13.4	0.6	-6.9	-7.7	-8.3	-9.2	-9.5	-9.3
Барааны экспорт 3/	53.2	57.5	68.5	62.7	60.0	58.9	55.1	53.1	53.3
Барааны импорт	44.3	50.3	46.1	48.8	45.4	45.4	43.7	43.7	43.7
Гадаад валютын нийт албан нөөц (GIR, сая ам.долл) 4/	4366	3400	4921	5027	5140	5828	6736	7159	7580
(импортын сараар)	4.3	3.0	3.7	3.6	3.4	3.7	4.0	4.0	4.0
(банкуудын МБ дахь валютын харилцахын үлдэгдлийг хассан дүн)	3612	1949	3612	...	...	...	...	...	...
Гадаад валютын цэвэр албан нөөц (NIR, сая ам.долл) 5/	779	-797	720	...	...	...	...	...	...
Валютын хани									
Төгрөг/ам.доллар (хугацааны эцэст)	2849	3445	3411	...	...	...	...	...	...

Эх сурвалж: Монгол Улсын эрх баригчид, ОУВС-гийн мэргэжилтнүүдийн төсөөлөл.

1/ Эрчим хүчний татаасыг төсвөөс гаргасны дараа шинээр тооцно.

2/ МБ-ны Хятадын Ардын Банканд өгөх өглөгийг оруулаагүй дүн. 2022-2023 онуудын дотоод өрөнд Засгийн газрын Эрдэнэт үйлдвэртэй холбоотойгоор ХХБ-тай хийх төлбөр тооцооны хүрээнд МБ-наас авсан өр төлбөр, Хөгжлийн банкны дотоодоос татсан гадаад валютын зээлийн эх үүсвэр болон МБ-наас авсан зээлийг оруулсан.

3/ Төсөөлөлд 2024, 2025 оны нүүрсний экспортын хэмжээг 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан хэмжээ буюу 75 болон 80 сая тонноор тус тус авч аажим өссөөр 2029 он гэхэд 95 сая тоннд хүрэхээр тооцсон нь БНХАУ-ын нүүрсний эрэлт нэмэгдэж, нүүрс тээврийн үйлчилгээ илүү оновчтой болохыг харуулж байгаа. Мөн Оюутолгой ХХК-ийн зэсийн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын дунд хугацааны шинэчилсэн төлөвлөгөө, ТӨК-ийн оффтэйк гэрээнүүдийн шинэчилсэн мэдээллийг төсөөлөлд тусгасан.

4/ Гадаад валютын нийт албан нөөц (GIR)-д Хятадын Ардын банктai байгуулсан своп хэлцлийн ашигласан дүн, ОУВС-гаас 2021 онд хийсэн ЗТЭ-ийн хуваарилалтыг оруулсан.

5/ NIR нь GIR-с арилжааны банк, засгийн газрын МБ дах ам.долларын харилцахын үлдэгдэл, Хятадын Ардын Банкны своп хэлцлийн дүн, ОУВС-д өгөх өглөгийг хасч тооцсон дүн.